

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТЫН КОД:

ДУА-2022/1/НА-СТА-ТЕЗ

Дарга, тэргүүлэх аудитор:

Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг:

Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал

Утас: 70592225

Цахим хаяг:

Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Батсайхан

Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn

Аудитор Д.Должинсүрэн

Цахим хаяг: Doljinsurend@audit.gov.mn

Утас: 7059-3113

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 1/04.

Мандалговь

**Аудитын тайланг
баталгаажуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх үүрэг”-ийн 1.1, 1.3, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 18 дугаар зүйлийн 9-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл”-д хийсэн аудитын тайланг /ДУА-2022/1/НА-СТА-ТЕЗ/-г нэг дүгээр хавсралтаар, аудитаар илэрсэн зөрчил, төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл”-д хийсэн аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

4. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан үр дүнгийн талаар 2022 оны 11 сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Ц.Мөнхбат/, ерөнхий санхүүч /С.Энхжаргал/-д тус тус зөвлөсүгэй.

5. Аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2022 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг Аудитын нэгдүгээр нэгжийн ахлах аудитор /Т.Батсайхан/, аудитор /Д.Должинсүрэн/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

0012010144



Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	4
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	13
3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	13
3.5.2 Авлага	14
3.5.3 Бараа материал.....	15
3.5.4 Үндсэн хөрөнгө.....	16
3.5.5 Өр төлбөр.....	17
3.5.6 Засгийн газрын хувь оролцоо	18
3.5.7 Орлогын данс	18
3.5.8 Зардал.....	18
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаар тайлбар, тодруулга	19
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	20
3.8 Аудитын гол асуудал.....	20
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	21
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
4. Аудитын илрүүлэлт.....	22
4.1 Албан шаардлага.....	23
4.3 Зөвлөмж	24
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	26



Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БТСГ	Бие тамир, спортын газар
БХС	Байгаль хамгаалах сан
ГИЦС	Говийн ирээдүй цогцолбор сургууль
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчийн Хурал
МХС	Мал хамгаалах сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗС	Тусгай зориулалтын сан
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТХДЖТ	Төв халхын дуулалт жүжгийн театр
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭДЦС	Эрдмийн далай цогцолбор сургууль
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭШТҮ	Эрдэм шинжилгээ, туршилт үйлчилгээ
ЭЭС	Эмийн эргэлтийн сан



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ ТАНАА**

2022. 04.20. № 12.

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Дундговь аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар Цагаандэлгэр, Гурвансайхан, Хулд сумдын нэгтгэсэн санхүүгийн тайлан, Цагаандэлгэр, Дэлгэрцогт, Говь-Угтаал, Гурвансайхан сумдын Засаг даргын Тамгын газрууд, Цагаандэлгэр сумын Эрүүл мэндийн төв зэрэг нийт 8 санхүүгийн тайлан “Хязгаарлалттай”, Сайнцагаан сумын Говийн Ирээдүй сургууль “Сөрөг” дүгнэлт авч, Хулд сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд аудит хийхээс “Татгалзсан” байна.

Төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй, үндсэн хөрөнгийг бүртгэлд тайланд тусгаагүй, бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан зэрэг зөрчил илэрсэн нь материаллаг дүнтэй бөгөөд санхүүгийн тайланд бүрэн тархаагүй.

Эдгээр нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 1.3 дахин их иж бүрэн байх, толилуулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0012020959



Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ



2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		27,203,909.6	37,384,564.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	8,720,246.7	11,548,772.2
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	5,080,998.0	7,816,154.8
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	7,393,579.7	9,044,393.2
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	211,186.7	176,077.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	5,797,898.6	8,799,166.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		145,698,452.4	161,537,291.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	145,698,452.4	161,537,291.2
39200	Биет хөрөнгө		118,981,614.0	134,754,434.9
39300	Биет бус хөрөнгө	13	26,716,838.4	26,782,856.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		172,902,362.1	198,921,855.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		10,074,587.5	13,845,425.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	645,154.1	1,690,110.2
41300	Өглөг	17а, 17б	645,154.1	1,097,189.2
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		9,429,433.4	12,155,315.5
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	9,429,433.4	12,155,315.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		162,827,774.6	185,076,429.5
51	Засгийн газрын хувь оролцоо		162,827,774.6	185,076,429.5
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		77,300,847.4	74,794,381.5
51200	Хуримтлагдсан үр дүн		38,871,735.9	63,329,939.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		46,655,191.2	46,952,108.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		172,902,362.1	198,921,855.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		74,324,949.0	91,236,850.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО		5,912,012.5	7,743,307.5
110	Орлогын албан татвар		4,267,933.5	4,737,544.4
1100	Хувь хүний орлогын албан татвар		4,580,278.7	5,020,658.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(312,345.2)	(283,114.2)
113	Хөрөнгийн албан татвар		443,920.2	1,184,143.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж		1,200,158.8	1,821,619.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	61,422,100.7	74,818,897.7
120	Нийтлэг татварын бус орлого		16,011,998.3	28,858,803.1
121	Хөрөнгийн орлого		142,722.4	108,801.8
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		45,267,380.0	45,851,292.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		6,990,835.8	8,674,645.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	56,536,638.1	66,215,182.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ		56,536,638.1	66,215,182.2



210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		53,253,863.3	62,936,612.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		27,489,813.5	29,060,494.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		3,447,765.2	3,769,815.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		4,277,753.2	4,837,471.4
2104	Хангамж, бараа материалын зардал		1,652,810.6	2,610,187.2
2105	Нормативт зардал		2,046,216.0	4,528,272.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		590,352.9	821,025.7
2107	Томилолт, зочны зардал		258,412.4	227,127.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,581,052.4	1,620,276.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		9,909,687.2	15,461,942.3
212	ТАТААС		421,268.8	1,186,801.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,861,506.0	2,091,768.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		17,788,310.9	25,021,668.2
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		1,246.0	784.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		8,347,248.2	4,946,319.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		9,442,308.7	20,076,133.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		64,318,348.3	69,013,577.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО		5,912,012.5	7,798,798.9
110	Орлогын албан татвар		4,267,933.5	4,742,544.4
1100	Хувь хүний орлогын албан татвар		4,580,278.7	5,025,658.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(312,345.2)	(283,114.2)
113	Хөрөнгийн албан татвар		443,920.2	1,184,143.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж		1,200,158.8	1,872,110.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		318,603.0	370,358.1
1181	Газрын төлбөр		597,964.6	605,158.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		283,591.2	896,594.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		51,509,759.2	54,686,474.2
120	Нийтлэг татварын бус орлого		6,099,656.8	8,726,379.6
121	Хөрөнгийн орлого		142,722.4	108,801.8
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		45,267,380.0	45,851,292.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		6,896,576.6	6,528,304.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		50,919,073.4	54,630,925.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ		50,919,073.4	54,630,925.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		47,621,907.9	51,811,600.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		28,037,848.4	29,632,404.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		3,515,875.7	3,845,642.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		4,455,676.3	5,038,460.1
2104	Хангамж, бараа материалын зардал		2,726,527.5	3,452,321.0



2105	Нормативт зардал		1,894,382.0	2,720,968.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,026,190.2	1,151,565.7
2107	Томилолт, зочны зардал		256,004.2	225,440.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,580,046.2	1,914,631.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,129,357.4	3,830,165.9
212	ТАТААС		432,899.1	661,089.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,864,266.3	2,158,236.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		13,399,274.9	14,382,652.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		8,960,198.8	10,702,549.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		8,960,198.8	10,702,549.9
2200	Дотоод эх үүсвэрээр		8,960,198.8	10,702,549.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		(8,960,198.8)	(10,702,549.9)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		(1,318,437.6)	(851,576.9)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		1,318,437.6	851,576.9
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		3,120,638.5	2,828,525.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		5,599,608.2	8,720,246.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		8,720,246.7	11,548,772.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	152,992,398.3	152,992,398.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	297,756.3	297,756.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	153,290,154.6	153,290,154.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(23,810.1)	(23,810.1)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	47,243.2	47,243.2
7	Өмчид гарсан өөрчлөлт	71,878.2	71,878.2
9	Тайлант үеийн үр дүн	9,442,308.7	9,442,308.7
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	162,827,774.6	162,827,774.6
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	162,827,774.6	162,827,774.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,109,172.5	2,109,172.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	164,936,947.1	164,936,947.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(92.0)	(92.0)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	10,800.0	10,800.0
17	Өмчид гарсан өөрчлөлт	52,641.3	52,641.3
19	Тайлант үеийн үр дүн	20,076,133.1	20,076,133.1
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	185,076,429.5	185,076,429.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/



Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	64,265,157.5	56,387,850.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	49,873,108.4	47,732,645.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	48,002,210.4	45,907,725.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,691,572.6	28,386,356.5
210101	Үндсэн цалин	18,953,955.7	18,865,142.9
210102	Нэмэгдэл	7,048,164.7	6,894,342.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	267,809.0	264,416.1
210104	Урамшуулал	2,141,947.5	2,098,852.0
210105	Гэрээт ажлын хөлс	279,695.7	263,603.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,750,807.2	3,676,482.3
210201	Тэтгэврийн даатгал	2,619,446.7	2,578,568.3
210202	Тэтгэмжийн даатгал	287,612.7	283,305.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	230,025.0	224,175.4
210204	Ажилгүйдлийн даатгал	58,839.8	55,149.8
210205	Эрүүл мэндийн даатгал	554,883.0	535,283.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,808,743.2	4,781,625.8
210301	Гэрэл, цахилгаан	305,258.5	292,708.9
210302	Түлш, халаалт	4,359,682.6	4,347,920.4
210303	Цэвэр, бохир ус	143,802.1	140,996.5
2104	Хангамж, бараа материалын зардал	1,427,279.5	1,413,398.0
210401	Бичиг хэрэг	161,505.3	160,712.9
210402	Тээвэр, шатахуун	619,687.5	612,798.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	114,469.7	112,656.0
210404	Ном, хэвлэл	32,034.6	30,709.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	75,726.3	73,725.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	423,856.1	422,796.2
2105	Нормативт зардал	1,432,052.7	1,343,437.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	602,763.5	531,638.4
210502	Хоол, хүнс	703,130.0	686,530.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	126,159.2	125,268.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,829,780.3	1,758,073.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	784,296.8	783,458.5
210602	Тавилга	254,610.7	222,813.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	21,454.6	11,815.0
210604	Урсгал засвар	769,418.2	739,986.2
2107	Томилолт, зочны зардал	228,882.5	214,115.0
210702	Дотоод албан томилолт	201,960.9	187,892.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	26,921.6	26,223.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,266,439.0	1,248,717.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,157,830.6	1,148,759.8
210803	Даатгалын үйлчилгээ	25,475.3	24,613.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	9,035.1	7,856.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,127.3	2,653.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	44,090.6	42,036.4
210807	Газрын төлбөр	13,398.3	9,837.4
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	13,481.8	12,960.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,566,653.4	3,085,519.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,405,776.9	2,925,677.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	160,876.5	159,841.8
212	ТАТААС	406,899.8	406,899.8
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	109,300.0	109,300.0
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	109,300.0	109,300.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	297,599.8	297,599.8



212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	297,599.8	297,599.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,463,998.2	1,418,020.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,463,998.2	1,418,020.1
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	272,700.8	260,537.6
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	643,168.2	637,602.1
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	1,603.0	1,593.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	277,826.0	251,334.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	268,700.2	266,952.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,245,591.0	7,803,628.9
223001	Бусад хөрөнгө	12,245,591.0	7,803,628.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,146,458.1	851,576.9
230001	Эргэж төлөгдөх зээл	2,146,458.1	851,576.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	64,265,157.5	57,823,192.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	34,909,231.5	34,758,162.8
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	28,214,560.1	28,068,689.3
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	6,694,671.4	6,689,473.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,234,113.3	20,149,434.2
320001	Орон нутгийн төсвөөс	21,234,113.3	20,149,434.2
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	409,224.3	215,199.0
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	409,224.3	215,199.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,712,588.4	2,700,396.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,433,894.1	1,769,030.7
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	734,668.7	931,365.3
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	5,544,025.6	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,839,275.1
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	7,292,486.2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЕЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,842,509.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,292,334.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,978,150.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	489,744.7
210101	Үндсэн цалин	85,163.2
210102	Нэмэгдэл	121,517.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,245.0
210104	Урамшуулал	262,046.5
210105	Гэрээт ажлын хөлс	18,772.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,331.7
210201	Тэтгэврийн даатгал	37,666.9
210202	Тэтгэмжийн даатгал	5,627.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,254.2
210204	Ажилгүйдлийн даатгал	902.3
210205	Эрүүл мэндийн даатгал	6,881.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,090.7
210301	Гэрэл, цахилгаан	13,229.1
210302	Түлш, халаалт	4,475.0
210303	Цэвэр, бохир ус	62,386.6
2104	Хангамж, бараа материалын зардал	302,633.8
210401	Бичиг хэрэг	24,672.6
210402	Тээвэр, шатахуун	112,095.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,071.4

ДУА-2022/1/НА-СТА-ТЕЗ



210404	Ном, хэвлэл	14,102.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	19,640.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	127,051.1
2105	Нормативт зардал	1,294,551.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,165,459.4
210502	Хоол, хүнс	102,978.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	26,113.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	329,693.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	181,243.2
210602	Тавилга	43,261.2
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,999.2
210604	Урсгал засвар	103,190.0
2107	Томилолт, зочны зардал	9,551.2
210702	Дотоод албан томилолт	9,551.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	342,179.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	341,361.6
210803	Даатгалын үйлчилгээ	54.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	58.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	630.5
210807	Газрын төлбөр	41.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,075,373.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,012,634.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	62,739.0
212	ТАТААС	245,439.3
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	245,439.3
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	245,439.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,068,744.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	497,620.3
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	260,100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,249.1
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	16.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	234,254.4
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	571,123.8
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	571,123.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	550,175.3
2200	Дотоод эх үүсвэрээр	550,175.3
223001	Бусад хөрөнгө	536,954.3
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,221.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,907,254.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,907,254.1
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	431,582.1
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,522,666.9
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	720,456.4
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	2,232,548.6
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	64,744.7
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.4
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	64,745.2

3. Аудитын тайлан



3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг Төсвийн ерөнхийлөн захирагч Ц.Мөнхбат танд танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Т.Батсайхан, аудитор Д.Должинсүрэн нар гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 04 дүгээр сарын 1-ний өдрийн 1/426 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дундговь аймгийн Засаг дарга нь эрхэм зорилгоо “Төр иргэн хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд ил тод байдлыг ханган хүн амын эрүүл аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж байгалийн тэнцвэрт байдлыг хангана” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна гэж дүгнэлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас 101 байгууллагад хяналт шалгалт хийгдэж, 9 байгууллагад 12 удаагийн 17,097.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож хэрэгжилт 89 хувь, 7 байгууллагад 139,367.5 мянган төгрөгийн хугацаатай албан шаардлага өгснөөс хэрэгжилт 85 хувь, давхардсан тоогоор 88 байгууллагад 368 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 90 хувьтай байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.



Дундговь аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 66,215.2 сая төгрөгийн 1 хувь буюу 662.2 сая төгрөгөөр тогтоов.

3.5 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 8,720.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 11,548.8 сая төгрөг болж, 2,828.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.1	0.1	-
Банканд байгаа бэлэн мөнгө	8,720.1	11,467.3	2,747.2
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	81.4	81.4
Хадгаламж	-	-	-
Дүн	8,720.2	11,548.8	2,828.6
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	4,948.4	6,135.1	1,186.7
Төсөл/ сан	1,083.3	1,827.6	744.3
Төрийн сан	2,649.8	3,408.1	758.3
ТӨҮГ болон ОНӨААТҮГ	38.7	178.0	139.3
Дүн	8,720.2	11,548.8	2,828.6

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 98.0 хувь нь Төрийн санд, 0.2 хувь нь арилжааны банканд байршиж байна.

Харилцах дансны үлдэгдэл өссөн шалтгаан нь ЭМТ-үүдийн харилцах дансны үлдэгдлийг жилийн эцэст төвлөрүүлээгүйгээс дансны үлдэгдэл 142.4 сая төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа Цагаандэлгэр сумын Соёлын төвийн барилгын барьцаа хөрөнгө 577.7 сая төгрөг, барьцаа хөрөнгөнд байршуулсан 14.7 сая төгрөг, сумдын ЗДТГ болон аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн төсөл хөтөлбөрийн зарцуулаагүй үлдэгдэл 571.1 сая төгрөг, он дамжиж хэрэгжих төслийн мөнгө, байгаль нөхөн сэргээн сангийн барьцаа хөрөнгө, Сум хөгжүүлэх сангийн иргэд, аж ахуйн нэгжид олгох мөнгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд орлогын данстай холбоотой нийт 633.7 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнээс материаллаг дүнтэй нийтлэг зөрчлийг дурдвал:

- Аудитаар ковидын шинжилгээний төлбөрийн орлогыг харилцах дансанд тушаагаагүй, дутуу төвлөрүүлж дутагдуулсан.. / Хулд сумын ЭМТ 2.0 сая, Адаацаг сумын ЭМТ 0.6 сая /
- Мөнгөн гүйлгээний тайлангийн эхний үлдэгдэл, орлого, зардлыг зөрүүтэй тайлагнасан. /Сайнцагаан сумын 3-р цэцэрлэг 20.4 сая, Дундговь Ус ОНӨААТҮГ 172.3 сая, Хулд ЭЭС 58.5, Цагаандэлгэр сумын Цэцэрлэг 10.5 сая /
- Мөнгөн гүйлгээний тайлангийн эдийн засгийн ангилал буруу бүртгэсэн. /Дэрэн ЭМТ 141.5 сая, Гурвансайхан сумын ЭМТ 68.5/

Шийдвэрлэсэн нь: 615.9 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 2.6 сая төгрөгийн зөрчлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 15.2 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.



3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 5,081.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 7,816.1 сая төгрөг болж, 2,734.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Авлага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон авлага	11.2	16.8	5.6
Төлбөртэй үйлчилгээний авлага	9.8	2,147.1	2,137.3
Дансны авлага / ОНӨААТҮГ /	215.5	394.4	178.9
Татвар НДШ / ОНӨААТҮГ /	1.1	1.6	0.5
Байгууллагаас авах авлага	1,314.1	2,290.0	975.9
Хувь хүмүүсээс авах авлага	308.6	410.7	102.1
Зээлийн хүүгийн авлага	29.6	22.6	(7.0)
ЗГ бусад шатны төсөвт олгосон зээл	43.0	-	(43.0)
Хувь хүмүүст олгосон зээл	2,498.5	1,792.1	(706.4)
Хувийн хэвшлийн ААНБ олгосон зээл	649.6	740.8	91.2
Дүн	5,081.0	7,816.1	2,735.1
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	1,522.5	4,724.3	3,201.8
Төсөл/ сан	3,296.0	2,672.4	(623.6)
Төрийн сан	43.0	-	(43.0)
ТӨҮГ болон ОНӨҮГ	219.5	419.4	199.9
Дүн	5,081.0	7,816.1	2,735.1

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын данс өссөн шалтгаан нь Сумдын ЭМТ-үүд Эрүүл мэндийн даатгалын сангаас цар тахлын эмчилгээний 2,140.8 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан, Засгийн газар, аймгийн Засаг дарга, Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын гуравласан гэрээний дагуу Дундговь-Ус ОНӨААТҮГ-аас авах цэвэрлэх байгууламжийн 2,725.9 сая төгрөгийн авлагыг тус тус бүртгэсэнтэй холбоотой байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт авлагын 2.4 хувь буюу 209.1 сая төгрөг нь 5 жилээс дээш насжилттай авлага байна. Дээрх авлага нь эргэн төлөгдөхгүй, найдваргүй болох эрсдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд авлагын данстай холбоотой нийт 1,063.1 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнээс материаллаг дүнтэй нийтлэг зөрчлийг дурдвал:

- Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй. / Баянжаргалан сумын ТЗС 31.8 сая, Өндөршил сумын ТЗС 26.8 сая, Дэрэн сумын ТЗС 20.6 сая, Дэлгэрхангай сумын ТЗС 35.9 сая, Сайхан-Овоо сумын ТЗС 23.9 сая, Аймгийн ЗДТГ 16.3 сая, Аймгийн ТЗС 21.4 сая, ТХДЖТ 6.0 сая, Аймгийн ОНХС 19.5 сая Сайхан-Овоо сумын ЭЭС 18.8 сая, Өлзийт 5.2 сая, Баянжаргалан сумын ЭЭС 11.8 сая /
- Санхүүгийн тайланд авлагыг тусгаагүй, илүү, дутуу зөрүүтэй тайлагнасан /Цагаандэлгэр сумын СХС 15.1 сая, Говь-Угтаал сумын ЕБС 8.5 сая, Гурвансайхан сумын ЗДТГ 5.0 сая, Өлзийт сумын ЭМТ 167.3 сая, Дэлгэрхангай сумын ЕБС 25.9 сая, БОАЖГ 8.6 сая, аймгийн ОНХС 63.3 сая, Дэлгэрцогт сумын ЭМТ 192.5 сая /
- Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтрэлттэй зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдээгүй /Цагаандэлгэр сумын СХС 42.5 сая, Гурвансайхан сумын СХС 24.8 сая, Хулд сумын СХС 14.2 сая, Адаацаг сумын СХС 6.6 сая, Дэлгэрцогт сумын СХС 7.4 сая/



Шийдвэрлэсэн нь: Авлагын данстай холбоотой дээрх зөрчлүүдэд 95.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 280.4 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 687.2 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулсан.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 13,402.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 18,019.7 сая төгрөг болж, 4,617.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	1,868.4	2,209.9	341.5
Эм боох материал	358.9	928.9	570.0
Бэлэн бүтээгдэхүүн	6.8	6.1	(0.7)
Бичиг хэргийн материал	287.4	318.6	31.2
Аж ахуйн материал	2,905.6	3,551.3	645.7
Сэлбэг хэрэгсэл	83.1	75.2	(7.9)
Түлш, шатах тослох материал	101.2	70.1	(31.1)
Барилгын засварын материал	241.9	218.9	(23.0)
Хүнсний материал	57.8	168.8	111.0
Бусад хангамжийн материал	381.0	472.6	91.6
Мал амьтад	1,101.5	1,024.0	(77.5)
Нөөцийн бараа	211.2	176.1	(35.1)
Бусад эргэлтийн хөрөнгө	5,797.9	8,799.2	3,001.3
Дүн	13,402.7	18,019.7	4,617.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	7,171.6	8,948.8	1,777.2
Төсөл/ сан	244.5	299.6	55.1
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	5,986.6	8,771.3	2,784.7
Дүн	13,402.7	18,019.7	4,617.0

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст 9,142.8 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, үнэ төлбөргүй буюу хандиваар 7,353.2 сая төгрөг, шилжүүлэн авсан 175.1 сая төгрөг, бусад 118.6 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан 47.4 сая төгрөгийн бараа материалаар нэмэгдэж, 15,221.4 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, шилжүүлсэн байна.

Нийт бараа материалын үлдэгдлийн 51.3 хувь нь төсөвт байгууллага болон төсөл сан, 48.7 хувийг ОНӨААТҮГ-т байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд бараа материалын данстай холбоотой нийт 770.7 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнээс материаллаг дүнтэй нийтлэг зөрчлийг дурдвал:

- Санхүүгийн тайланд бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй, буруу тайлагнасан / Сайхан-Овоо сумын ОНХС 97.5 сая, Дэрэн сумын ЗДТГ 24.5 сая, Сайнцагаан сумын ЭМТ 378.6 сая/
- Бараа материалын үлдэгдлийг тооллого хийж баримтжуулаагүй /Дэрэн сумын Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээ ОНӨААТҮГ 60.6 сая, Өндөршил сумын ЭМТ 4.0 сая, Цагаандэлгэр сумын МХС 11.6 сая/
- Шатахууны зардлыг хяналтгүй зарцуулж, зарцуулалтын тооцоог бодож, баталгаажуулаагүй. /Хүлд сумын ЭМТ 2.0 сая, Говь-Угтаал сумын ЗДТГ 18.7 сая, Баянжаргалан сумын ЭМТ 10.2 сая, Цагаандэлгэр сумын ЗДТГ 27.2 сая/
- Хяналтын тооллогоор бараа материал дутаасан, анхан шатны баримт бүрдэл дутуу баримтаар хөрөнгө зарцуулсан. /Дэлгэрцогт сумын ЗДТГ 5.2 сая, Сайнцагаан сумын ЗДТГ 3.0 сая, Дэлгэрцогт сумын ЭМТ 4.6 сая, Дэлгэрцогт сумын ЗДТГ 14.1 сая/



Шийдвэрлэсэн нь: Бараа материалын данстай холбоотой дээрх зөрчлүүдэд 5.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 154.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 1.1 сая төгрөгийн зөвлөмж өгч, 610.1 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулсан.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 169,693.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 190,589.3 сая төгрөг болж 20,896.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	116,165.8	131,933.4	15,767.6
Тээврийн хэрэгсэл	6,024.9	7,332.6	1,307.7
Машин тоног төхөөрөмж	10,894.9	13,639.8	2,744.9
Тавилга эд хогшил	5,311.7	5,941.1	629.4
Дуусаагүй барилга	2,228.4	2,228.4	-
Түүх соёлын дурсгалт зүйл	926.6	932.0	5.4
Номын фонд	691.9	714.5	22.6
Биет бус хөрөнгө	26,877.4	26,948.1	70.7
Бусад үндсэн хөрөнгө	571.6	919.4	347.8
Дүн	169,693.2	190,589.3	20,896.1
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	131,160.0	151,766.7	20,606.7
Төсөл/ сан	17.3	17.4	0.1
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	38,515.9	38,805.2	289.3
Дүн	169,693.2	190,589.3	20,896.1

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдлийн 79.6 хувийг төсөвт байгууллага, төсөл сан, 20.4 хувийг ОНӨААТҮГ-ын хөрөнгийн үлдэгдэл эзэлж байна. Нийт хөрөнгийн 85.9 хувийг биет хөрөнгө, 14.1 хувийг газар болон биет бус хөрөнгө эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн үндсэн хөрөнгө 1,257.5 сая төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 3,372.8 сая төгрөг, үнэ төлбөргүй буюу хандиваар авсан 19,013.6 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан 558.1 сая төгрөг бусад 2,833.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгөөр тус тус нэмэгдэж 6,130.1 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, акталж данснаас хассан байна.

Дуусаагүй барилга дансанд 1,600.0 сая төгрөгийн Төв халхын дуулалт жүжгийн театрын барилга, 200.0 сая төгрөгийн Дэлгэрхангай сумын Хүн эмнэлгийн барилга, 62.9 сая төгрөгийн Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн нэгдсэн халаалтын барилга, Дэлгэрцогт сумын Засаг даргын Тамгын газрын 365.5 сая төгрөгийн цэвэр усны шугам сүлжээний барилгын санхүүжилтийн эх үүсвэр дутагдсантай холбоотой нийт 2,228.4 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн данстай холбоотой нийт 1,557.9 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнээс материаллаг дүнтэй нийтлэг зөрчлийг дурдвал:

- Үндсэн хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаагүй, зөрүүтэй дүнгээр тусгасан. /Аймгийн ЗДТГ 410.6 сая, БОАЖГ 20.7 сая, Гурвансайхан сумын ЗДТГ 68.2 сая, Өндөршил сумын ЗДТГ 70.4 сая, Эрдэнэдалай сумын Цэцэрлэг 38.5 сая/



- Тайлант онд төсвийн хэмнэлтийн талаар авах хэмжээг зөрчин тавилга, эд хогшил худалдан авсан. /Аймгийн ЗДТГ 14.6 сая, Баянжаргалан сумын ЗДТГ 7.5 сая, Гурвансайхан сумын ЗДТГ 17.0 сая, Өлзийт сумын ЗДТГ 16.5 сая/
- Сумын ИТХ-аар оны эцэст төсөвт тодотгол хийн, хэмнэлтийн горим зөрчин эд хогшил, урсгал засварын зардлыг нэвээгдүүлэн баталсан. /Адаацаг сум 52.5 сая, Гурвансайхан сум 107.1 сая, Говь-Угтаал сум 124.0 сая, Дэрэн сум 71.8 сая, Өлзийт сум 53.9 сая, Хулд сум 58.9 сая/
- Биетээр байхгүй хөрөнгийг бүртгэн, хөрөнгө дутаасан. /Дэлгэрхангай сумын ЗДТГ 46.5 сая, Цагаандэлгэр, Луус, Адаацаг сумын тус бүр 3.9 сая/

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгөтэй холбоотой дээрх зөрчлүүдэд 412.7 сая төгрөгийн албан шаардлага, 492.6 сая төгрөгийн зөвлөмж өгч, 652.6 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 10,074.6 сая, эцсийн үлдэгдэл 13,845.4 сая төгрөг болж, 3,770.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн /+/, Буурсан/-/
Богино хугацаат өр төлбөр дүн	645.2	1,690.1	1,044.9
Өглөг	645.2	1,690.1	1,044.9
Ажилчидтай холбогдсон өглөг	29.4	80.3	50.9
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	-	-	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	132.4	403.8	271.4
Зээлийн хүүгийн өглөг	0.1	0.3	0.2
Бусад өглөг	483.3	612.7	129.4
Урьдчилж орсон орлого	-	593.0	593.0
Урт хугацаат өр төлбөр дүн	9,429.4	12,155.3	2,725.9
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	9,429.4	12,155.3	2,725.9
			-
Нийт дүн	10,074.6	13,845.4	3,770.8
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	2,197.3	3,261.9	1,064.6
Төсөл, сан	139.3	90.0	(49.3)
Төрийн сан	43.0	-	(43.0)
ТӨҮГ болон ОНӨҮГ	7,695.0	10,493.5	2,798.5
ДҮН	10,074.6	13,845.4	3,770.8

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст 1,690.1 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөр бүртгэгдсэний 36.3 хувь нь бусад өр төлбөр, 23.9 хувь нь бараа үйлчилгээний зардлын өр төлбөр, 4.8 хувь нь ажилчидтай холбогдсон өр төлбөр, 35.0 хувь нь урьдчилж орсон орлого, 0.02 хувь нь зээлийн хүүгийн өр төлбөр байна.

Богино хугацаат өр төлбөрийн дүнд 166.1 сая төгрөгийн насжилт өндөртэй, материаллаг дүнтэй дараах өр төлбөр байна. Үүнд:

- Цагаандэлгэр сумын ЭЭС-ийн 23.9 сая төгрөгийн эмийн өр;
- Сайхан-Овоо, Говь-Угтаал сумын Мал хамгаалах сангийн 33.5 сая төгрөгийн өвсний өр;
- Баянжаргалан, Өндөршил сумдын Байгаль хамгаалах сангийн 60.4 сая төгрөгийн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн өр;
- Төв халхын дуулалт жүжгийн театрын шинээр баригдах барилгын 41.2 сая төгрөгийн зураг төсвийн өр.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын Азийн хөгжлийн банкны “Нийтийн аж ахуйг хөгжүүлэх төсөл”-тэй холбоотой 2,191.9 сая төгрөг, Азийн хөгжлийн банкнаас хэрэгжиж буй цэвэрлэх байгууламжийн төслийн 8,075.9 сая төгрөг, Гурвансайхан суманд Азийн хөгжлийн банкны санхүүжилтаар хэрэгжсэн “Хот байгуулалтын салбарын төсөл”-ийн хүрээнд үүссэн нийт 12,155.3 сая төгрөгийн өр байна.



Аудитын илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд өр төлбөрийн данстай холбоотой нийт 36.8 сая төгрөгийн зөрчлүүд илэрлээ. Үүнээс материаллаг дүнтэй нийтлэг зөрчлийг дурдвал:

- Санхүүгийн тайлан дахь өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй /Хулд сумын ТЗС 30.4 сая, Гурвансайхан сумын ТЗС 4.7 сая/
Шийдвэрлэсэн нь: Өр төлбөртэй холбоотой дээрх зөрчлүүдэд 0.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 35.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 1.6 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулсан.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 162,827.7 сая, эцсийн үлдэгдэл 185,076.4 сая төгрөг болж 22,248.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7 Засгийн газрын оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт +/-
ЗГ-ын оруулсан капитал	77,300.8	74,794.4	(2,506.4)
Хуримтлагдсан үр дүн	38,871.7	63,329.9	24,458.2
Өмнөх үеийн үр дүн	29,429.4	43,253.8	13,824.4
Тайлан үеийн үр дүн	9,442.3	20,076.1	10,633.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	46,655.2	46,952.1	296.9
			-
Дүн	162,827.7	185,076.4	22,248.7
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	121,479.3	143,306.9	21,827.6
Төсөл, сан	4,494.1	4,718.2	224.1
Төрийн сан	2,649.7	3,408.1	758.4
ТӨҮГ болон ОНӨААТҮГ	34,204.6	33,643.2	(561.4)
Дүн	162,827.7	185,076.4	22,248.7

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны нийт үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 1,433.9 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогыг 734.7 сая төгрөг, нийт 2,168.6 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого 1,769.0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 931.4 сая төгрөг, нийт 2,700.4 сая төгрөгөөр тайлагнажээ.

Тайлант хугацаанд 6,551.7 сая төгрөгийн татварын болон татварын бус орлого бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 7,793.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 1,242.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Орлогын төлөвлөгөө биелсэн нь дараах 4 нэр төрлийн орлогын гүйцэтгэлээс шалтгаалсан байна. Үүнд:

- Газрын төлбөр 1.4 дахин;
- Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт 4 дахин;
- Хөрөнгө борлуулсны орлого 3 дахин;
- Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр 4.2 дахин давж биелсэн байна.

3.5.8 Зардал

Хүснэгт №6 /сая төгрөг/

ДУА-2022/1/НА-СТА-ТЕЗ



Үзүүлэлт	2021		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт бууралт
Бараа, ажил үйлчилгээний зардал	48,002.2	45,907.7	(2,094.5)
Татаас ба урсгал шилжүүлэг	1,870.9	1,824.9	(46.0)
Хөрөнгийн зардал	12,245.6	7,803.6	(4,442.0)
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл	2,146.5	851.6	(1,294.9)
Нийт дүн	64,265.2	56,387.8	(7,877.3)

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Зардлын бууралт нь орон нутгийн авто замын санхүүжилт 206.5 сая төгрөг, шилжсэн хөрөнгө оруулалт 288.7 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгө 207.1 сая төгрөг, төсөвт байгууллагын урсгал зардлаас 295.4 сая төгрөгийн зардлыг хэмнэж, төсөл сангуудын үлдэгдлийг зарцуулаагүйтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд зардлын данстай холбоотой нийт 2,221.5 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнээс материаллаг дүнтэй нийтлэг зөрчлийг дурдвал:

- ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад эдийн засгийн тооцоо судалгаа, зураг төсөв нь хийгдээгүй 18 нэр төрлийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг баталсан./Говь-Угтаал сумын ОНХС 190.6 сая, /

- Байгаль хамгаалах сангаас 2021 оны байгаль хамгаалах сангийн орлого, зарлагын төлөвлөгөөг сумын ИТХ-аар батлуулалгүй зарцуулсан / Хулд сумын БХС 14.6 сая /

- Орон тоо, цалингийн төсөв батлагдаагүй орон тоонд ажилтан авч цалинжуулан, төсвийг зориулалт бусаар зарцуулсан, цалин, урамшуулал, нэмэгдлийг илүү, дутуу олгосон. /Сайнцагаан сумын Цэгц билиг сургууль 6.4 сая, Говийн ирээдүй сургууль 18.8 сая/

- Зочид төлөөлөгчдөд өгөх бэлэг буюу бараа материалыг шууд зарлагаар хяналтгүй зарцуулсан. /Аймгийн ЗДТГ 14.0/

- "Спорт заалны шал засварлах материал нийлүүлсэн харилцагчтай холбоотой төлбөрийн цахим баримтыг харилцагчаас гаргуулан аваагүй, бүрдэл дутуу анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн. /БТСГ 31.6 сая/

- "Гамшигийн эсрэг хэрэгжүүлэх арга хэмжээ" "Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа хангах дэд хөтөлбөр" иргэдийн санал аваагүй төсөл хөтөлбөр санхүүжүүлсэн. /Эрдэнэдалай сумын ОНХС 70.0 сая, Хулд сумын ОНХС 9.9 сая, Өндөршил сумын ОНХС 10.0 сая, Адаацаг сумын ОНХС 9.3 сая/

Шийдвэрлэсэн нь: Зардалтай холбоотой дээрх зөрчлүүдэд 13.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 521.5 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 29.7 сая төгрөгийн зөвлөмж өгч, аудитын явцад 1,657.2 сая төгрөгийн алдааг залруулсан.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаар тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 64,265.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл



Тайлант онд аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 64,265.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 49,873.1 сая төгрөгийг урсгал зардалд, 12,245.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 2,146.5 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 28,214.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 409.2 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 21,234.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 2,168.6 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос, 5,544.0 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс, 6,694.7 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 28,136.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 215.2 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 21,006.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,377.5 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос, оны эхний үлдэгдлээс 323.1 сая төгрөгийг, 6,477.4 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас нийт 57,536.8 сая төгрөгийн санхүүжилтийг авсан нь батлагдсан төсвөөс 6,728.4 сая төгрөгөөр дутуу байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 56,387.9 сая төгрөг буюу 98 хувьтай байна. /Төсвийн гүйцэтгэлийн тайланг 2.5-аас харна уу/

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр нийт 5,907.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс бараа ажил үйлчилгээний зардалд 3,978.2 сая, урсгал шилжүүлгийн зардалд 1,068.7 сая, хувийн хэвшилд олгох татаас 245.4 сая, хөрөнгийн зардалд 550.2 сая, нийт 5,842.5 сая төгрөгийг зарцуулж 64.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд ковидын нөхцөл байдал болон хаврын шороон шуурганы аюултай үзэгдэлд хүнд гарз хохирол амссан нутгийн иргэддээ тухайн нутагт хайгуулын болон ашиглалтын зөвшөөрөлтэй уул уурхайн компаниуд болон нутгийн иргэдээс хандив өгсөн байна. Тухайн хандивын мөнгийг орон нутгийн онцгой комиссын үйл ажиллагаанд, гэр оронгүй болсон иргэдэд шинэ гэр авч өгөх, оюутны сургалтын төлбөр, малчдад нүүхэд зориулж шатахууны зардал зэрэгт зарцуулж, үлдэгдэл мөнгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

Цар тахалтай холбоотой иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас өгсөн хандив, тусламжийг аймаг, сумын онцгой комиссын хяналтын постын шатахуун, хүнс, хамгаалах хэрэгсэл зэрэгт зарцуулжээ.

Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн яамнаас эм, эмийн хэрэгслүүдийг аймгийн ЭМГ-аар дамжуулан хуваарилсан байна. Хуваарилсан эмийн үнийг зөрүүтэй бүртгэсэн, эм, эмнэлгийн хэрэгсэл, вакциныг орлогод аваагүй, зарлагыг тайлагнаагүй зэрэг зөрчлүүд илэрч аудитын явцад бүх ЭМТ болон өрхийн Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлан залруулга хийгдсэн.

Бүх сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны халаалтын төлбөрийг м.куб-ээр тооцож олгосныг 2022 оноос м.кв-аар тооцуулахаар сургуулиудад зөрчил арилгах албан шаардлага хүргүүлээ.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант онд Хулд сумын Эрүүл мэндийн төв нь байгууллагын орон тоо, цалингийн санд батлагдаагүй 2 орон тоонд эрх бүхий албан тушаалтны хамаарал бүхий этгээдийг авч ажиллуулсан. Мөн ковидын төлбөртэй шинжилгээний орлогыг төсвийн дансанд төвлөрүүлээгүй, өөрийн хувийн дансаар авч ашиглан, санхүүгийн тайланд тусгаагүй. Анхан шатны баримтгүй шатахууны зардал гаргасан зэрэг ашиглангийн шинжтэй зүйл илэрсэн.

Иймд бараа материалын тайлан нь үнэн зөв гарсан гэх хангалттай, зохистой нотолгоо олж авах боломжгүй, энэ нь санхүүгийн тайланд материаллаг бөгөөд өргөн тархсан тул дүгнэлт өгөхөөс татгалзсан.



Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн санхүүгийн тайлангийн аудитаар сургуулийн ажилтнуудад ажлын хувцас захиалахдаа төсвийн хэмнэлтийн горимыг зөрчин, барилгын материалын дэлгүүрээр дамжуулан 3.0 сая төгрөгийг бэлнээр гарган авч, жилийн эцсийн тооллогоор биетээр байхгүй хувцсыг байгаагаар тоолон, баталгаажуулсан, албан хаагчдын ээлжийн амралтын цалинг илүү тооцон олгож, 18,798.8 мянган төгрөгийн цалингийн зардлыг нийгмийн даатгалын тайланд дутуу тайлагнасан зэрэг зөрчил нь материаллаг бөгөөд өргөн тархсан тул сөрөг дүгнэлт авсан.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Засаг дарга нь 2021 онд нийт 158 мэдээллээс 148 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн, хугацаанд нь байршуулж, 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол, Орон нутгийн хөгжлийн сангийн журам зөрчсөн зөрчлүүдийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 292 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Аж ахуйн харилцааны дүрэм” зөрчсөн зөрчлүүдийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийсэн. Завсрын аудитаар нийт 412.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 214.7 сая төгрөгийн 35 алдааг залруулж, 1.3 сая төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 173.7 сая төгрөгийн 25 зөрчилд албан шаардлага, 22.6 мянган төгрөгийн 8 зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Өмнөх оны Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд ажил сайжруулах 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	3		3				100
Нийт	3		3				100



3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлд дараагийн шууд тайлагнах аудитаар горим, сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 117 төсвийн байгууллага, 17 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, 31 тусгай зориулалтын сан, 15 сумын нэгтгэсэн тайлан, нийт 180 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 103 байгууллагыг аудитад хамруулан, 77 санхүүгийн тайланд дүгнэлт өгсөн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 104 байгууллагыг түүвэрт хамруулж, 76 байгууллагад дүгнэлт хүргүүлээ. Үүнд: “Зөрчилгүй” 66, “Хязгаарлалттай” 8 /Цагаандэлгэр, Гурвансайхан, Хулд сумдын нэгтгэсэн санхүүгийн тайлан, Цагаандэлгэр, Дэлгэрцогт, Говь-Угтаал, Гурвансайхан сумдын ЗДТГ, Цагаандэлгэр сумын ЭМТ/, “Сөрөг” 1 /Сайнцагаан сумын Говийн Ирээдүй сургууль/, “Татгалзсан” 1 /Хулд сумын ЭМТ/ дүгнэлт гаргасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 6,432.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 4,330.6 сая төгрөгийн 201 алдааг аудитын явцад залруулж, 116.7 сая төгрөгийн зөрчилд 40 төлбөрийн акт тогтоож, 1,442.3 сая төгрөгийн зөрчилд 209 албан шаардлага, 543.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 41 зөвлөмж өглөө.

Аймгийн нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 32.7 хувийг залруулагдаагүй, 67.3 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Алдаа зөрчлийг ангиллаар нь харуулбал ихэнх буюу 4,947.0 сая буюу 76.9 хувь нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай, 954.3 сая буюу 14.8 хувь нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 452.1 сая буюу 7.0 хувь нь дотоод хяналт хариуцлагатай холбоотой алдаа, 62.3 сая буюу 1 хувь нь худалдан авалттай холбоотой, 10.9 сая буюу 0.2 хувь нь зориулалт бус зарцуулалттай холбоотой, 6.1 сая буюу 0.1 хувь нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой зөрчил тус тус илэрсэн байгаа нь дотоод хяналтыг сайжруулан нягтлан бодогч нарын ур чадвар, хариуцлагыг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

Сумдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн төвлөрүүлэн захирагчийн 15 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 12, “Хязгаарлалттай” 3 /Цагаандэлгэр, Гурвансайхан, Хулд сумдын нэгтгэсэн санхүүгийн тайлан/ дүгнэлт гаргасан байна.

Аудитаар нийт 697.4 сая төгрөгийн 48 алдаа, зөрчил илрүүлснээс 47.2 сая төгрөгийн 15 алдааг аудитын явцад залруулж, 151.7 сая төгрөгийн 20 зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага, 498.4 сая төгрөгийн 13 зөрчилд зөвлөмж өгсөн.

Сумдын байгаль хамгаалах сан, мал хамгаалах сангийн санхүүгийн тайланг сумын Засаг даргын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн аудитаар үзэж, шилэн дансны хэрэгжилт, насжилт өндөртэй авлагыг барагдуулах ажил зохион байгуулах, хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж ажиллах, сумдын нягтлан бодогч, төсвийн шууд захирагч нарын ур чадвар, эрх зүйн мэдлэгийг сайжруулах талаар зөвлөж ажиллаа.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн 117 байгууллагаас 56 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 60 санал дүгнэлт гаргаснаас “Зөрчилгүй” 53, “Хязгаарлалттай” 5 / Цагаандэлгэр, Дэлгэрцогт, Говь-Угтаал, ДУА-2022/1/НА-СТА-ТЕЗ



Гурвансайхан сумдын ЗДТГ, Цагаандэлгэр сумын ЭМТ /, “Сөрөг” 1 / Сайнцагаан сумын Говийн Ирээдүй сургууль/, “Татгалзсан” 1 /Хулд сумын ЭМТ/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 4,411.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3,816.3 сая төгрөгийн 161 алдааг аудитын явцад залруулж, 20.9 сая төгрөгийн 27 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 529.6 сая төгрөгийн 156 зөрчилд албан шаардлага, 44.9 сая төгрөгийн 28 алдаа, зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 17 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг аудит хамруулснаас 16 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 1 санал дүгнэлт гаргахаас “Зөрчилгүй” /Дундговь-Ус ОНӨААТҮГ/ гарсан байна.

Аудитаар нийт 484.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 281.6 сая төгрөгийн 20 алдааг аудитын явцад залруулж, 203.2 сая төгрөгийн 17 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 31 тусгай сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамрууллаа. Аудитаар нийт 757.3 сая сая төгрөгийн 34 алдаа, зөрчил илрүүлснээс 185.5 сая төгрөгийн 5 алдааг залруулж, 95.7 сая төгрөгийн 13 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 476.0 сая төгрөгийн 15 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 алдаа, зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 1, арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой 1, нийт 2 зөвлөмжийг хүргүүлээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 81.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 81.7 сая төгрөгийн 2 албан шаардлага, хуулийн хэрэгжилттэй холбоотой, арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой 2 зөвлөмж өглөө.

4.1 Албан шаардлага

1. Техник хяналтын сангаас үйл ажиллагаанд хамааралгүй 60.3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг бусад байгууллагад худалдан авсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 */төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/*, мөн хуулийн 41.2.2 */батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах/*, Аймгийн Засаг даргын 2018 оны А/118 дугаар захирамжаар баталсан “Техник хяналтын зардлыг захиран зарцуулах журам” –ын 3.1.2-т */Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр техник хяналт тавихад шаардлагатай автомашин тоног төхөөрөмж, хэмжих багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас, тавилга эд хогшил худалдан авах/ анхан шатны баримт нэхэмжлэлийг үндэслэнэ/* гэж заасныг тус тус зөрчсөн.
2. Санхүүгийн тайлан дахь 21.4 сая төгрөгийн зураг төслийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д */дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/*, мөн хуулийн 20.2.6-д */эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/* заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг дахин давтан гаргуулахгүй байхаар 81.7 сая төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.



4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт:

Дундговь аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын шилэн дансны цахим мэдээллийг хоцроож мэдээлсэн болон огт мэдээлээгүй 32 байгууллагад зөрчлийг арилгах 19 албан шаардлага, 13 зөвлөмж хүргүүлсэн.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмыг уншиж судлан хэрэгжилтэд хяналт тавих, мэдээллийг хугацаанд бүрэн байршуулах, ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах;

2. Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой

Илрүүлэлт:

Бүх сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны халаалтын төлбөрийг м.куб-ээр тооцож олгосон.

Өгсөн зөвлөмж:

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 292 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Аж ахуйн харилцааны дүрэм”-ийн 5.3.1-т /Аливаа барилга байгууламж, орон сууц нь дулааны тоолуур суурильдаагүй бол дулааны эрчим хүчний төлбөр тооцоог энэхүү дүрэмд заасны дагуу эзлэхүүн болон талбайн хэмжигдэхүүнээр гэрээний дагуу тооцно. Орон сууцны барилгыг ахуйн зориулалтаар нь ашиглаж, хүн амьдарч байгаа бол талбайн хэмжигдэхүүнээр, үүнээс бусад нөхцөлд эзлэхүүнээр тооцно/ заасны дагуу Ерөнхий боловсролын сургуулиудын дотуур байрны халаалтын талбайг талбайн хэмжигдэхүүнээр тооцон гэрээг шинэчлэн байгуулж, төсвийг хэмнэлттэй зарцуулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 7 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	ТЕЗ	0	-						-		
2	ТТЗ	16	537.8				-	6	53.8	10	484.0
3	ТШЗ	79	231.0			2	3.4	64	225.7	13	1.9
4	ОНӨААТҮГ	1	-				-	1	-		
5	ТЗС	8	198.8		-			7	198.8	1	
	дүн	104	967.6	-	-	2	3.4	78	478.3	24	485.9
2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	ТЕЗ	2	81.7		-		-	2	81.7		-
2	ТТЗ	26	159.5	9	47.2	-	-	14	97.9	3	14.4

ДУА-2022/1/НА-СТА-ТЕЗ



3	ТШЗ	299	4,180.8	167	3,816.3	25	17.4	92	303.9	15	43.1
4	ОНӨААТҮГ	36	484.8	20	281.6	-	-	16	203.2	-	-
5	ТЗС	26	558.5	5	185.5	13	95.8	8	277.2		-
	дүн	389	5,465.3	201	4,330.6	38	113.2	132.0	964.0	18	57.6
	Нийт зөрчлийн дүн	493	6,432.9	201	4,330.6	40	116.6	210	1,442.3	42	543.5

Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

(сая.төгрөгөөр)																				
Д/д	Харьяа байгууллага	Аудитад хамрагдсан хэлбэр					Нийт зөрчил		Залруулсан		Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Үүнээс			
		Түүвэрт хамрагдсан	Дүгнэлт														Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		Хариуцлага тооцох санал	
			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТЕЗ			1			2	81.7	0	-	0	-	2	81.7						
2	ТТЗ		12	3			48	697.4	15	47.2		-	20	151.8	13	498.4				
3	ТШЗ	56	54	5	1	1	372	4,411.7	161	3,816.3	27	20.9	156	529.6	28	44.9				
4	ОНӨААТҮГ	16	1				37	484.8	20	281.6	0	-	17	203.2	0	-				
5	ТЗС	31	0				34	757.3	5	185.5	13	95.8	15	476.0	1	-				
	НИЙТ ДҮН	121	67	8	1	1	493	6,432.9	201	4,330.6	40	116.7	210	1,442.3	42	543.3	0		0	

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн
тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар тогтоосон төлбөрийн актын нэгтгэл /төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн утга	Төлбөрийн акт	
			Тоо	Дүн
1	Адаацаг СХС	Адаацаг сумын төсөл хэрэгжүүлэгч Л.Отгонсүрэн нь гэрээнд заасны дагуу үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлснээс Сум хөгжүүлэх санд хохирол учруулсан.	1	6,617,518.00
2	Адаацаг ЭМТ	Ковидын шинжилгээний төлбөр 606,000.00 төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн.	1	606,000.00
3	АЗДТГ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч нарт хүндэтгэл үзүүлэхдээ Аймгийн ИТХ-аас баталсан бэлэг дурсгалын зүйл гардуулах зардлын нормативаас илүү олгосон	1	977,999.00
4	Боржигон мандал өрхийн эмнэлэг	Коронавируст халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ үзүүлж ажилласан эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг дэмжих зорилгоор нэг удаа олгосон мөнгөн тэтгэмжийг ажилчдаас нярвын дансаар дамжуулан буцаан хураан авч, анхан шатны баримтгүй, тодорхой бус зардалд зарцуулсан.	1	1,500,000.00
5	Гурвансайхан ЗДТГ	Төсвийг орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээнд бүрдэл дутуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан.	1	1,500,000.00
6	Гурвансайхан СӨБ	Үр дүнгийн урамшууллыг илүү олгосон	1	237,849.00
7	Гурвансайхан СХС	Гурвансайхан сумын нэр бүхий 2 төсөл хэрэгжүүлэгч гэрээнд заасны дагуу үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн, зээлийг зориулалтын дагуу ашиглаагүйгээс Сум хөгжүүлэх санд хохирол учруулсан байна.	2	24,761,078.00
8	Говь-Угтаал ЕБС	Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон	1	159,842.00
9	Говь-Угтаал ЭМТ	Албан томилолтоор ажилласан албан хаагчдад хоолны мөнгийг цалингийн сангаас давхардуулан олгосон.	1	128,000.00
10	ГХБХБГ	Эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнгийн урамшууллыг журамд заасан хэмжээнээс 217,731.00 төгрөгөөр хэтрүүлэн олгосон	1	217,731.00
11	Дэлгэрхангай СӨБ	Хяналтын тооллогоор бараа материал дутагдсан	1	134,196.00
12	Дэлгэрхангай ЭМТ	Өндөр насны тэтгэвэр тогтоолгоод үргэлжлүүлэн ажиллаж байгаа ажилтанд байгууллагаас түлшний хөнгөлөлт давхардуулан олгосон.	1	163,260.00
13	Дэлгэрцогт СХС	Дэлгэрцогт сумын төсөл хэрэгжүүлэгч Ч.Доржпүрэв нь гэрээнд заасны дагуу үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлснээс Сум хөгжүүлэх санд хохирол учруулсан.	1	7,388,111.00
14	Дэрэн ЭМТ	Бараа үйлчилгээний бусад зардлаас ажилчдад дархлаа дэмжих зорилгоор олгосон бүтээгдэхүүнд амттан оруулж, төсвийг хэмнэлтгүй, зориулалт бусаар зарцуулсан.	1	135,000.00
15	Дэрэн ЭМТ	Ажилчдад урамшуулал олгохдоо хуульд заасан хэмжээнээс хэтрүүлэн татварын хөнгөлөлт эдлүүлсэн.	1	550,968.00
16	Луус ИТХ	Шуудан холбоо, интернэтийн төлбөрөөс нэгжний мөнгө олгосон	1	40,000.00
17	Номын сан	Хөрөнгө зарцуулах шийдвэргүйгээр албан хаагчид нэмэгдэл цалин бодож олгосон.	1	321,754.00
18	Номын сан	Албан хаагчид цолны нэмэгдэл олгохдоо холбогдох журмаас өндөр хувиар бодож олгосон.	1	321,754.00
19	Өлзийт ЗДТГ	Албан хаагчдад 205,835.00 төгрөгийн цалинг илүү тооцож олгосон.	1	205,835.00
20	Өлзийт ЭМТ	Ажлаас гарсан болон ажилд шинээр орсон 2 ажилтанд 400,000.00 төгрөгийн ковидын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эмч, албан хаагчдад олгосон нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг олгосон.	1	400,000.00
21	Өндөршил ЕБС	Хяналтын тооллогоор хүнсний материал дутагдсан.	1	75,100.00
22	Өндөршил ЭМТ	Албан томилолтоор ажилласан албан хаагчдад 47,000.00 төгрөгийн хоолны мөнгийг цалингийн сангаас давхардуулан олгож, албан томилолтын зардлаас 16.000.00 төгрөгийг илүү тооцож олгосон.	1	63,000.00

23	Сайнцагаан 1-р цэцэрлэг	Хоол хүнсний зардлаас анхан шатны баримтгүйгээр 88,705.00 төгрөгийн хоолны материал зарцуулсан.	1	88,705.00
24	Сайнцагаан ГИЦС	Сургуулийн захирал ээлжийн амралтаараа төрсөн нутагтаа очиж амрах замын зардал илүү олгосон	1	165,400.00
25	Сайнцагаан ГИЦС	Сургуулийн 58 ажилчдын ээлжийн амралтын мөнгийг зөрүүтэй тооцож олгосон	1	2,031,269.62
26	Сайнцагаан ГИЦС	Ажилтнуудад ажлын хувцас захиалахдаа барилгын материалын дэлгүүрээр дамжуулан бэлнээр гарган авч, жилийн эцсийн тооллогоор биетээр байхгүй хувцсыг байгаагаар тоолж, баталгаажуулсан	1	3,000,000.00
27	Сайнцагаан ЗДТГ	Засаг даргын нөөц сангаас тэмцээн зохион байгуулж хэмнэлтийн горим зөрчсөн.	1	3,295,960.00
28	Сайнцагаан Мандал сургууль	Ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд тушаалаар шагнал нөхөн олгосон	1	621,078.00
29	Хулд СХС	Хулд сумын төсөл хэрэгжүүлэгч М.Жаргалсайхан, С.Ганхүрэл, Ш.Цогзолмаа нар гэрээнд заасны дагуу үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлснээс Сум хөгжүүлэх санд хохирол учруулсан байна.	3	14,226,018.00
30	Хулд ЭМТ	Аудитаар ковидын шинжилгээний төлбөр 1,967,000 төгрөгийн орлогыг харилцах дансанд тушаагаагүй, бэлэн мөнгөний үлдэгдэлд тайлагнаагүй, дутаасан.	1	1,967,000.00
31	Хулд ЭМТ	Албаны машиныг хувьдаа ашиглаж, анхан шатны баримтгүй 2,001,200 төгрөгийн шатахууны зардал гаргасан.	1	2,001,200.00
32	Цагаандэлгэр ОНХС	Сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтад ороогүй, иргэд олон нийтийн саналыг аваагүй, жагсаалтаар эрэмбэлэгдээгүй, зориулалт бус “Санхүүгийн программын сунгалт” -ын зардлыг санхүүжүүлсэн.	1	240,000.00
33	Цагаандэлгэр СХС	Цагаандэлгэр сумын төсөл хэрэгжүүлэгч нь гэрээнд заасны дагуу үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлснээс Сум хөгжүүлэх санд хохирол учруулсан.	5	42,524,625.00
Нийт дүн			40	116,666,250.62

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар хүргүүлсэн албан шаардлагын нэгтгэл /төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн утга	Албан шаардлага	
			Тоо	Дүн
1	Адаацаг ЕБС	Аудитаар санхүүгийн тайлан дахь 4,235,654.00 төгрөгийн хувь хүнээс авах авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй.	1	4,235,654.00
2	Адаацаг ЕБС	Сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлсэн.	1	
3	Адаацаг ЗДТГ	Орон тоо, цалингийн сан батлагдаагүй ажлыг 4, 6, 9 саруудад хавсарган гүйцэтгэж, ажил хавсарсны нэмэгдэл цалин бодож олгосон.	1	581,934.00
4	Адаацаг ЗДТГ	Адаацаг сумын хөрөнгө орлогын мэдүүлэг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд олгох нэмэгдэл болон Төрийн нууц хамгаалах чиг үүргийг хариуцах ажилтанд олгох нэмэгдлийг 10 хувиар буюу 794,696 төгрөгөөр илүү олгосон.	1	794,696.00
5	Адаацаг ЗДТГ	Төсвөөс хэмнэлтийн ЗГ-ын 43-р тогтоолыг зөрчиж, тэмдэглэлт ой, урлагын наадам, уралдаан тэмцээнд 4,217.0 мянган төгрөгийг зарцуулсан.	1	4,217,000.00
6	Адаацаг ИТХ	Аудитаар хөрөнгө орлогын мэдүүлэг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд олгох нэмэгдлийг илүү олгосон.	1	1,132,680.00

7	Адаацаг ОНХС	Төсөвт тодотгол хийж иргэд олон нийтийн саналыг аваагүй, жагсаалтаар эрэмбэлэгдээгүй, зориулалт бус “Гамшгийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээ” -ний урсгал зардлыг санхүүжүүлсэн.	1	9,290,000.00
8	Адаацаг Соёл	Байгууллагын албан хэрэгцээнд сандал ширээ худалдан авч, хэмнэлтийн горим зөрчсөн.	1	1,850,000.00
9	Адаацаг СӨБ	Цалингийн зардлаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогчоос төлөх зардлаас төлсөн.	1	393,397.00
10	Адаацаг ТЗС	БХС-Санхүүгийн тайлан дахь 200,000 төгрөгийн хувь хүнээс авах авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй.	1	200,000.00
11	Адаацаг ЭМТ	Орон тоо, цалингийн сан батлагдаагүй ажлыг хавсруулан гүйцэтгүүлж, ажил хавсарсны нэмэгдэлд 3,135,264 төгрөгийн цалин бодож олгосон.	1	3,135,264.00
12	Адаацаг ЭЭС	Аудитаар санхүүгийн тайлан дахь 1,009,426.00 төгрөгийн хувь хүн, албан байгууллагаас авах авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй	1	1,009,426.00
13	АЗДТГ	Зочид төлөөлөгчдөд өгөх бэлэг буюу бараа материалыг шууд зарлагаар хяналтгүй зарцуулсан	1	14,091,200.00
14	АЗДТГ	Тайлант онд төсвийн хэмнэлтийн талаар авах хэмжээг зөрчин 5,160,000.00 төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авахад, 9,512,190 төгрөгөөр сургалт, семинар зохион байгуулахад зарцуулсан	1	14,672,190.00
15	АЗДТГ	Аудитаар санхүүгийн тайлан дахь өндөр насжилттай төгрөгийн 16,289,100 төгрөгийн өглөг авлагын тооцоо нийлээгүй, барагдуулах арга хэмжээ аваагүй	1	16,289,100.00
16	АИТХ	Бичиг хэргийн ажилтны батлагдаагүй орон тоонд ажил хавсарсны нэмэгдэл цалин бодож олгосон.	1	2,833,914.00
17	АИТХ	Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд 70 мэдээллийг хоцроож, 1 мэдээллийг байршуулаагүй байна.	1	
18	Баянжаргалан ЕБС	Байгууллагын ажилчдад дархлаа дэмжих хүнсийг олгож хөдөлмөр нийгмийн хамгааллын зардлаас төлсөн.	1	1,450,000.00
19	Баянжаргалан ЗДТГ	ЗД-ын нөөц сангаас шинэ жилийн арга хэмжээ зохион байгуулж хэмнэлтийн горим зөрчсөн.	1	1,000,000.00
20	Баянжаргалан ЗДТГ	Төсвөөс тавилга эд хогшил худалдан авч хэмнэлтийн горим зөрчсөн.	1	7,538,000.00
21	Баянжаргалан ИТХ	Байгууллагын албан хэрэгцээнд морин хуур, шүүгээ худалдан авч, хэмнэлтийн тогтоол зөрчсөн.	1	2,580,000.00
